

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭХ, ЭЦЭГ, ОЛОН ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ, ЭЦЭГТ ТЭТГЭМЖ ОЛГОХ
ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдөр баталсан Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдөр баталсан Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д дараах агуулга бүхий хэсэг нэмсүгэй.

1/ 97дугаар зүйлийн 97.2 дахь хэсэг:

97.2.Энэ хуулийн 97.1.2, 97.1.6-д заасан нийтээр амрах баярын өдрүүд долоо хоногийн бямба, ням гарагийн аль нэг өдөр, эсхүл бямба, ням гарагт дараалан тохиосон тохиолдолд дараагийн ажлын эхний нэг, эсхүл хоёр өдөр нийтээр нөхөн амарна.

2 дугаар зүйл. Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/144 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“144.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага эсхүл нийт ажилтны дийлэнх нь хөгжлийн бэрхшээлтэй аж ахуйн нэгж, байгууллагын эсхүл хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг гэрээгээр байнга худалдан авах зэргээр тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн ажил олгогчийг энэ хуулийн 144.3-т заасан төлбөрөөс чөлөөлж, хөнгөлж болно.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 88 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй.

1/88 дугаар зүйлийн 88.1.10 дахь заалт:

“88.1.10.Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуульд заасны дагуу олгож байгаа мөнгөн дэмжлэг.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Орон сууцны тухай тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалтыг нэмсүгэй.

“9.4.4.ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай зэрэг гэр бүлд ээлтэй орчныг хүртээмжтэйгээр төлөвлөх.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуульд дор дурдсан агуулга бүхий 13.16 дахь хэсэг, 13.1.7 дахь заалт нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13.16 дахь хэсэг:

13.16.0-18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг улирал бүр тэтгэмж авах эрхтэй бөгөөд хүүхдийн тоонд төрүүлсэн болон үрчлэн авсан, асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа хүүхдийг хамааруулна.

2/13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалт:

13.1.7.гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж.

2 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.6 дахь хэсгээс “энэ хуулийн 13.5.9-д заасан иргэнд жилд нэг удаа” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.13, 13.14, 13.15 дахь хэсэг, 13.1.6, 13.5.9 дахь заалтыг тус тус хүчингүй болгосугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль **хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АВТО ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Авто тээврийн тухай хуулийн 17¹ дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалтыг нэмсүгэй.

“17^{1.4}. Энэ хуулийн 17^{1.3}-т заасан орлогыг Хүүхдийн төлөө санд төвлөрүүлнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

202... оны ... дугаар

сарын ...-ны өдөр

Дугаар

Төрийн ордон, Улаанбаатар хот

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй:

1/Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн дагуу 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмж авахаар тогтоолгосон тэтгэмжийг эх, эцэг, асран хамгаалагч эрх дуусах хүртэл хугацаанд сар бүр хэвээр олгох;

2.Энэ тогтоолыг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль **хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.**

ГАРЫН ҮСЭГ